

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ХӨНӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

"ИЖ БҮРЭН ГЭР ЦЭЦЭРЛЭГ" ХУДАЛДАН
АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022 оны 12-р сарын 05-ны өдөр

№ 2092/248.


Улаанбаатар хот

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт
1	Иж бүрэн гэр	<ol style="list-style-type: none">1. Их таван ханатай, бетонон суурьтай, шалны халаалт, паркетин шалтай иж бүрэн гэр байна.2. 2 давхар бор эсгий, сайн чанарын 6 утастай брезентэн, цагаан бүрээстэй, зуны өвлийн 2 өрхтэй, хаалганы эсгий дулаалгатай байх3. 3-6 насны хүүхдүүд өвөл зунгүй байрлах тул маш чанартай байна.4. Гэрийн дагалдах хэрэгслүүд иж бүрэн байх бөгөөд, ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу гэрийг хооронд нь холбох, сургалтын зориулалтаар ашиглахад бэлэн болгох.5. Модон суурьтай, сайн чанарын хуванцар гоожууртай, төмөр /никель/ тосгууртай, тольтой, савангийн суурьтай угаалтуур байна. 15 хүүхэд тутамд 1 ш байхаар тооцно.6. 2-6 насны хүүхдийн эрүүл ахуйн шаардлагад тохирсон 10л багтаамжтай био суултуур дагалдах бодистой байна.
2	Дагалдах хэрэгсэл	<ol style="list-style-type: none">1. Гэрийн мод: Гэрийн бүх модыг хатаасан модоор "Монгол гэрийн мод MNS 370:2003", "Монгол гэр. Техникийн ерөнхий шаардлага MNS 0370:2011" стандартын дагуу үйлдвэрлэх ба модыг стандартын шаардлага хангасан үнэр багатай, тогтоц сайтай будгаар хоёр давхарлаж будсан байна.2. Гэрийн тооно: Гэрийн тооныг хоролт тооны загвараар дөрвөн ширхэг рамтай, модон хадаасаар холбосон байна. Чагтага уях гархинуудыг бүрэн бэхэлсэн байна. Тооныг хуш, нарсан модоор хийсэн байна.3. Гэрийн унь: Хар модон цуулбар модоор хийсэн байх бөгөөд хялгасан сагалдрагатай хийнэ. Нэг гэр 81 уньтай байхаас гадна нөөц уньтай байна. (5-аас доошгүй)4. Гэрийн хана: Хар модон цуулбар байхаас гадна уламжлалт аргаар үдээрээр үдсэн, 15 толгойтой хана байна. Ханын үзүүрт нь цагийн зүүний дагуу дугаарласан байх.5. Гэрийн багана: Баганын тархи, далбааг хооронд нь углуурга заадлан холболтоор цавуудаж холбосон байна.6. Гэрийн хаалга: 6 яс модтой, 2 нугас, хаалганы гадна, дотор тус бүр 2 бариул, 6 ширхэг гархитай байна.

7. Гэрийн шал: Бетонон суурьтай, шалны халаалттай, сайн чанарын паркетаар хийсэн, хивс, хивсэнцэр байна.
8. Гэрийн бүрээс болон дагалдах бүс, уяа: Гэрийн бүх эсгий нь MNS 296: 2012 "Машинт аргаар үйлдвэрлэсэн ноосон эсгий. Техникийн шаардлага" стандартын шаардлагад нийцсэн цэвэр хонины ноос байна. Шивтэрийн үнэргүй байх.
9. Эсгий дээвэр: Дээврийг цэвэр хонины ноосоор хийсэн бор эсгийгээр хийж, ирмэгийг хөвөрдөж оёсон байна. 2 талдаа 30-50 см-ийн зөрлөгтэйгөөр 2 давхар хийнэ.
10. Эсгий туурга: Хонины цэвэр ноосон бор эсгийгээр хийж, хоолой болон ирмэгийг хөвөрдөж оёсон байна. 2 талдаа 30-50 см-ийн зөрлөгтэй, туурга тус бүр нь 8ш гогцоотой, 4м урттай, 4ш оосортой байна. Туурга нь 2 давхаргатай тооцно.
11. Эсгий өрх: Хонины цэвэр ноосоор хийсэн бор эсгийг ус нэвтэрдэггүй цагаан бүрээсээр оёж өнгөлсөн байна.(өрхний 4 буланд бэхэлж оёсон 3.0 метр-ээс доошгүй урттай оосор, бүчтэй байна.)
12. Брезентэн өрх: Ус нэвтэрдэггүй сайн чанарын брезентийг 2 давхарлаж хийсэн байна. (өрхний 4 буланд бэхэлж оёсон 3.0 метр-ээс доошгүй урттай оосор, бүчтэй байна.)
13. Хаалганы дулаалга: Бор эсгийг ус нэвтрүүлдэггүй даавуун материалаар битүү өнгөлж оёсон, 140*140 см-ын хэмжээтэй байна.
14. Даавуун гадуур цагаан бүрээс: 2 давхар оёдолтой, гэмтэл согоггүй, сайн чанарын цагаан ямбуугаар хийсэн, 100 см зөрлөгтэй, оосор бүчтэй байна.
15. Даавуун дотуур цагаан бүрээс /цаваг/: 2 давхар оёдолтой, сайн чанарын цагаан ямбуугаар хийсэн, 100 см зөрлөгтэй, оосор бүчтэй байна.
16. Брезентэн бүрээс: Ус нэвтэрдэггүй сайн чанарын /6 утастай/ брезентен материалаар дээвэр, туургыг нь үргэлж хийсэн. Давхар оёдолтой, 60 см-ээс багагүй зөрлөгтэй хийх.
17. Хөшиг: Гэрийн дотуур хөшигийг хөвөн даавуугаар, булан хээтэй, 60 см зөрлөгтэй, давхар машиндаж хийсэн байна. (цулгүй өнгөөр)
18. Хаяавч: Сайн чанарын брезентийг 2 давхарлаж хийсэн, 80 см тутамд бат бөх бүч тогтоосон, их 5 ханатай гэрт таарахуйц 20 м-ээс доошгүй урттай, 40 см-ийн өргөнтэй байна.
19. Гадуур, дотуур бүслүүр /хошлон/: Хялгас томж хийсэн, эсвэл түүнтэй дүйцэхүйц чанартай материалаар хийсэн байна.
20. Тоононы гол болон дааган чагтага: Сарлагийн саваг болон хялгасыг томж хийсэн 4.6м-ээс багагүй урттай гол чагтага 1ш , 2.8м-ээс урттай дааган чагтага 4ш байна.
21. Тоононы шилэн рам: Их 5 ханатай гэрийн тоононд таарахуйц шиллэсэн 4ш рам байна.
22. Унины хамгаалалтын уяа: 5 ханатай гэрийн униг хооронд нь бат бөх холбох цэвэр мяндас, сунадаггүй, тасардаггүй, 50м-ээс багагүй хэмжээтэй байх.

3	Гэрийн суурь	Бетоноор хийгдсэн, Их 5 ханатай гэр бүрэн багтахаар байна. 15 см өндөртэй. Суурийн дулаалгатай байна.
4	Халаалт, дулаан	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн үеийн технологи бүхий иж бүрэн цахилгаан халаагууртай, халаагуурын дээгүүр сайн чанарын бүдэг өнгийн паркетаар хийнэ. Цахилгаан халаагуур байрлуулах, холболт хийх, шал угсрах зэрэг бүх ажлыг гүйцэтгэгч хариуцаж хийнэ. Эргэлтийн насос болон шалны халаалт, түүний дагалдах хэрэгсэл цөм бүрэн байна. 2. 8квт хүчин чадалтай, 220ВТ ажиллах боломжтой. Суурилуулалт багтана.
5	Дараах стандарт хангасан байх	<p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Монгол гэрийн мод MNS 370:2003" - "Монгол гэр. Техникийн ерөнхий шаардлага MNS 0370: 2011" - Модны чийглэгийг MNS 2470: 78,; - Гадаргуугын барзгарыг MNS 2386:77 - Холболтын бат бэхийг MNS 2721:94; - Цавуун холболтын ус тэсвэрлэх чадварыг MNS 2722:79 - Эд ангийн холболтын хэлбэрийг MNS 2447 - Будгийн хучилтын хатуулгийг MNS 2398:89 - Бусад холбогдох норм, дүрэм
6	Санхүүжилт	<ul style="list-style-type: none"> - Бараа бүтээгдэхүүнийг ашиглагч, захиалагч байгууллагуудад акт үйлдэж хүлээлгэн өгсөнөөр гэрээнд тусгасан санхүүжилтийг 100 хувь нийлүүлэгч талд шилжүүлнэ.

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ДАРГА

...../Б.ЛХАГВАЖАВ/ ✓

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН СХОТХ-ИЙН ДАРГА

...../О.БАДАМСЭРЭЭЖИД/

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЖР

...../Э.БАТЦЭНГЭЛ/

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
СӨББ-ЫН БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН

...../Д.ИРМҮҮНЗАЯА/